

ТЭНГЭР ФАНД МЕНЕЖМЕНТ ХХК
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү Эрсдэлийн удирдлагын журам (цаашид “Журам” гэх)-ын зорилго нь Тэнгэр Фанд Менежмент ХХК (цаашид “Компани” гэх)-ийн үйл ажиллагаанд учрах эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, түүнээс үр ашигтай гарах замаар эрсдэлийг удирдахтай холбогдон харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Компани өөрийн эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаанд Монгол Улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны Зах Зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын Сангийн тухай хууль, Санхүүгийн Зохицуулах Хороо (цаашид “Хороо” гэх)-ны холбогдох журам, Сантай холбогдох журам болон бусад холбогдох хууль, журмыг мөрдөнө.

ХОЁР. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ЗАРЧИМ, БОДЛОГО

- 2.1. Компанийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхэд ил тод байх, шударга, бодитой байх, эрсдэлийг хэт төвлөрүүлэхгүй байх, хөрвөх чадварын зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг баримтална.
- 2.2. Компанийн эрсдэлийн удирдлагын зорилго нь компанийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлох, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах, сангийн хөрөнгө оруулалтын шийдвэрт эрсдэл бүхий хөрөнгө оруулалтыг бодлогоор зохицуулах зэргийг тооцоход оршино.
- 2.3. Эрсдэлийн удирдлагын бодлого, заавар, журмууд Компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд үйлчлэх ба удирдлага, эрх бүхий албан тушаалтан бүр дагаж мөрдөнө.

ГУРАВ. ЭРСДЭЛИЙН ТӨРӨЛ, ТӨВШИН

- 3.1. Эрсдэл гэж Компанийн зорилго, чиглэлд хүрэхэд тохиолдож болзошгүй үр дагавар, гарз хохирлыг ойлгоно.
- 3.2. Эрсдэлийг үүсгэж буй хүчин зүйлсээс хамааруулан доорх байдлаар ангилна. Үүнд:
 - 3.2.1. Хөрөнгө оруулалтын эрсдэл гэж Гадаад болон дотоод хүчин зүйлсийн нөлөөллөөс шалтгаалан Компанийн үйл ажиллагаанд учрах эрсдэл;
 - 3.2.2. Үйл ажиллагааны эрсдэл гэж Дотоод хүчин зүйлсийн нөлөөллөөс шалтгаалан, үйл ажиллагаанд учрах эрсдэл;
- 3.3. Компанийн эрсдэлийг Алсын харааны (Хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичгийн хүрээнд), зорилтын (Богино хугацааны хөрөнгө оруулалтын бодлогын төвшинд), Үйл ажиллагааны (албан тушаалтны төвшинд) гэсэн 3 төвшинд тодорхойлно. Үүнд:
 - 3.3.1. Алсын харааны төвшинд Компанийн хөрөнгө оруулалтыг урт хугацаанд хүртэх өгөөж болон түүнд ногдох эрсдэлийг тодорхойлно.
 - 3.3.2. зорилтын төвшинд хөрөнгө оруулалтын орчин болон макро эдийн засгийн нэг жил хүртэлх шинжилгээ, дүгнэлт дээр үндэслэн удирдаж буй хөрөнгө оруулалтын сан бүрийн зорилтот өгөөж болон түүнд ногдох эрсдэлийн хэмжээгээр тодорхойлно. зорилтын төвшний эрсдэл нь стратегийн төвшний эрсдэлээс өөр байж болно.
 - 3.3.3. Үйл ажиллагааны төвшинд Компани өдөр тутмын үйл ажиллагаанд удирдаж буй хөрөнгө оруулалтын сан бүрийг Хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичиг, дүрэм,

журам болон холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хэрхэн нийцтэй байдлаар удирдахыг тодорхойлно.

ДӨРӨВ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

- 4.1. Эрсдэлийн удирдлага гэж Компанийн үйл ажиллагааны бүхий л үе шатанд эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, эрсдэлд тохирох хариу арга хэмжээ авах тасралтгүй үйл ажиллагаа.
- 4.2. Эрсдэлийн удирдлага эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, түүнд тохирсон хариу арга хэмжээ авах гэсэн үндсэн үйл ажиллагаанаас бүрдэнэ. Үүнд:
 - 4.2.1. Орчноо тодорхойлох;
 - 4.2.2. Эрсдэлийг тодорхойлох;
 - 4.2.3. Эрсдэлийг тооцох;
 - 4.2.4. Эрсдэлийг үнэлэх;
 - 4.2.5. Эрсдэлийн хариу арга хэмжээг авах;
 - 4.2.6. Эрсдэлийн мониторинг хийх;
- 4.3. Эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааг Компанийн ТУЗ-өөс гаргасан зөвлөмжийн дагуу гүйцэтгэх удирдлага, сангийн менежерүүд хэрэгжүүлнэ.
- 4.4. Компанийн ТУЗ дараах байдлаар Эрсдэлийн удирдлагын арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:
 - 4.4.1. ТУЗ-ийн зүгээс эрсдэлийн удирдлагын хүчирхэг соёлыг бий болгоход манлайлан оролцох;
 - 4.4.2. Эрсдэлийг зүй зохистой удирдах тогтолцоог бүрдүүлэх, түүнтэй холбоотой журам, заавар боловсруулж эрсдэлийн менежментээр хангах;
 - 4.4.3. Эрсдэлийн удирдлагын иж бүрэн тогтолцоог Компанийн бүх төвшний үйл ажиллагаанд нэвтрүүлж, хэрэгжүүлж, тасралтгүй явуулах;
 - 4.4.4. Эрсдэлийн удирдлага, хяналтыг хэрэгжүүлэх алба нэгжүүдийн үйл ажиллагаа, эрх үүргийн хуваарилалтыг оновчтой болгох;
 - 4.4.5. Эрсдэлийг бууруулахад ашиглах хариу арга хэмжээг батлах;
 - 4.4.6. Эрсдэлийн удирдлагын бодлогыг тодорхойлох;
 - 4.4.7. Эрсдэлийн удирдлагын төлөвлөгөөг батлах;
 - 4.4.8. Эрсдэлийн хүлээн зөвшөөрөгдөх төвшнийг тодорхойлох;
 - 4.4.9. Стратегийн хүлээн зөвшөөрөгдөх төвшнийг тодорхойлох;
 - 4.4.10. Дотоод хяналтын нэгж, ажилтнаар дамжуулан эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, түүний хэрэгжилтэд хяналт тавих;
- 4.5. Компани дараах байдлаар Эрсдэлийн удирдлагын арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:
 - 4.5.1. Эрсдэлийн удирдлагын бодлого, төлөвлөгөөний дагуу эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх;
 - 4.5.2. Эрсдэл удирдлагын бодлого, төлөвлөгөөний дагуу эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх;
 - 4.5.3. Эрсдэлийг үнэлэх;
 - 4.5.4. Эрсдэлийн удирдлагын хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөг боловсруулах;
- 4.6. Эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаанд Монгол Улс, олон улсад тохиолдож байгаа эрсдэлийн удирдлагын шинэ мэдлэг, технологи, дотоод мэдээллийн системийг байнга судалж ашиглана.
- 4.7. Компанийн ТУЗ болон гүйцэтгэх удирдлага, сангийн менежерүүд нь эрсдэлийн удирдлагын тайланг хагас жилийн болон жилийн үйл ажиллагааны тайланд тусгасан байна.

ТАВ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН АРГА ХЭМЖЭЭ

- 5.1. Компанийн ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЭРСДЭЛИЙГ доорх байдлаар удирдана. Үүнд:
 - 5.1.1. Хөрөнгө оруулалтын сан тус бүр Хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичгийн хүрээнд эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлнэ.

- 5.1.2. Хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичигт хөрөнгө оруулалтын стратегийг тодорхойлсон байх ба түүний хүрээнд хөрөнгө оруулалтын хэрэгслүүдэд эрсдэлд тохирсон байдлаар хуваарилан.
- 5.1.3. Эдийн засгийн нөхцөл байдлаас хамааран сангийн онцлогт тохируулан эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлнэ.
- 5.1.4. Хөрөнгө оруулалтын хэрэгсэл тус бүрээр хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийг тооцох аргачлалыг хэрэгжүүлнэ. Хувьцааны Бодит үнэ цэнийг өмнөх өдрийн хаалтын ханшаар, Өрийн хэрэгслийн хувьд Бодит үнэ цэнийг өртгөөр, мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн Бодит үнэ цэнийг хуримтлагдсан хүүг нэмсэн байдлаар, бусад санхүүгийн хэрэгслийн хувьд олон улсын боломжит тооцооллын аргаар тооцно.
- 5.1.5. Их хэмжээний хэлцэл болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг ТУЗ-өөр шийдвэрлүүлнэ.
- 5.1.6. Сан тус бүрийн эрсдэлийн удирдлагыг авч хэрэгжүүлнэ.
- 5.2. Компанийн ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРСДЭЛИЙГ доорх байдлаар удирдана. Үүнд:
 - 5.2.1. Компани хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг хялбаршуулах, үйл ажиллагааны зардлыг бууруулах зорилгоор цахим хуудас болон гар утасны хэрэглүүр хөгжүүлнэ. Иймд цахим орчны мэдээллийн аюулгүй байдал, үйл ажиллагааны үр дүнтэй байдал, эрсдэл зэрэгт мэдээллийн системийн аудит хийлгэнэ.
 - 5.2.2. Уг аудитыг цахим орчныг хөгжүүлж дууссаны дараа нэг удаа бөгөөд цаашид ноцтой алдаа гарах, эсвэл нэмэлт хөгжүүлэлт хийлгэсэн зэрэг шаардлагатай нөхцөлд дахин хийлгэнэ.
 - 5.2.3. Боловсон хүчний эрсдэлийг бууруулах зорилгоор Хөрөнгө оруулалтын албанд ажиллах бүх ажилтан, мэргэжилтнийг Монгол Улсын Үнэт цаасны зах зээлд хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох сургалтад хамруулж, эрхийн үнэмлэх эзэмшүүлсэн байна.
 - 5.2.4. Хорооноос баталсан Хамтын сангийн үйл ажиллагааны журамд заасны дагуу Компаниас томилсон сангийн менежер мэргэжлийн хариуцлагын даатгалд зайлшгүй хамрагдана. Иймд сангийн менежерийн гаргасан санамсар, болгоомжгүй алдаа, түүнээс улбаалан Санд учрах тодорхой хэмжээний хохирлыг даатгалаар нөхөн төлүүлэх боломжтой.
 - 5.2.5. Компани нь жилд нэг удаа ёс зүйн тайлан, комплайнс тайлан гарган, үйл ажиллагааны тайланд хавсаргана.

ЗУРГАА. ХОРИГЛОХ ЗҮЙЛС

- 6.1. Компанид дараах үйл ажиллагааг хориглоно. Үүнд:
 - 6.1.1. Хөрөнгө оруулалтын шийдвэрийг зохих хөрөнгө оруулалтын судалгаа, шинжилгээнд үндэслэхгүйгээр гаргах;
 - 6.1.2. Компанийг төлөөлөн шийдвэр гаргахдаа сонирхлын зөрчилтэй шийдвэр гаргах, сонирхлын зөрчилтэй байдлаар хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалт хийх;
 - 6.1.3. Дотоод хяналтын ажилтан, Комплайнсын ажилтны хяналтын үйл ажиллагаанд саад учруулах, хамтран ажиллахгүй байх;
 - 6.1.4. Хууль тогтоомж зөрчсөн байдлаар хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах, хөрөнгө оруулалт хийх;
 - 6.1.5. Зах зээлийг урвуулан ашиглах, дотоод мэдээлэл ашиглаж хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах;
 - 6.1.6. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомж, Хорооны журам, шаардлага болон сангийн дүрэм, журмууд, ТУЗ-ийн шийдвэрийг зөрчих, хэрэгжүүлэхгүй байх;
 - 6.1.7. Хорооноос тогтоосон тохиромжтой этгээдийн шалгуурыг хангахгүй болох;

6.1.8. Монгол Улсын Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, бусад захиргааны актад тусгасан Үнэт цаасны зах зээл, Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаатай холбогдох хэсгийг зөрчих;

ДОЛОО. БУСАД

- 7.1. Журмыг ТУЗ баталж, нэмэлт өөрчлөлт оруулах ба түүний хэрэгжилтэд ТУЗ, гүйцэтгэх удирдлага, дотоод хяналтын ажилтан хяналт тавьж, Компанийн бүх шатны үйл ажиллагаанд дагаж мөрдөнө.
- 7.2. Журмыг зөрчиж Компанийн санхүүгийн болон бусад үйл ажиллагаанд аливаа эрсдэлийг учруулсан этгээдэд хууль тогтоомж, журамд заасныг үндэслэж хариуцлага тооцож, арга хэмжээ авна.

ТЭНГЭР ФАНД МЕНЕЖМЕНТ ХХК ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ЗААВАР

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү баримт бичгийг компанийн эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлэх, хэрэгжүүлэх, хянахад баримталж ажиллана.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 2.1. ТУЗ байгууллагын үйл ажиллагааны бүхий л чиглэлийг эрсдэлийн удирдлагаар хангаж, нэгдсэн үйл ажиллагааг хариуцан, дотооддоо мөрдөх зааврыг байгууллагын бизнесийн цар хүрээ, үйл ажиллагааны онцлог, бүтэц, зохион байгуулалтад нийцүүлэн батална.
- 2.2. Заавраар байгууллагын зорилго, зорилтод нөлөөлөх эрсдэл, ирээдүйд тохиолдох магадлал ба нөлөөллийг үнэлснээр эрсдэлд хариу өгөх арга хэмжээ, түүнийг үнэлэх үйл явцад хяналт хийх зэрэг эрсдэлийн удирдлагын хүрээг тодорхойлно.
- 2.3. ТУЗ зааварт нэмэлт, өөрчлөлт оруулах эрхтэй бөгөөд ТУЗ-ийн дэргэдэх **Дотоод хяналтын** нэгж, ажилтан эрсдэлийн удирдлага, түүний хэрэгжилтэд дотоод хяналтын нэгжээр дамжуулан хяналт тавина.
- 2.4. Энэхүү баримт бичгийг цаг үедээ тохируулан тухай бүр шинэчлэн батална.

ГУРАВ. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

- 3.1. Эрсдэлийг тодорхойлох: тулгарч буй хүндрэлийг шийдвэрлэх болон бизнесийн цар хүрээг нэмэгдүүлэх, гуравдагч талын харилцаа, зах зээлээс хамаарсан, эсхүл зохицуулалтын орчинд гарсан өөрчлөлт зэргээс үүсэх магадлалтай эрсдэлийг байгууллагын бүхий л түвшинд тодорхойлно. Ингэхдээ дараах хүчин зүйлсийг харгалзана:
 - 3.1.1. эрсдэлийн шинж чанар /nature of the risk/ - хаана, хэзээ, ямар үйл явдал;
 - 3.1.2. эрсдэлийн эх үүсвэр /source of the risk/ - ямар хүчин зүйлс, хүн, үйл ажиллагаа;
 - 3.1.3. эрсдэлийн шалтгаан /cause of the risk/ - шууд болон шууд бус шалтгаан;
 - 3.1.4. эрсдэлийн нөлөө /effect of the risk/ - үүсэх үр дагавар, хамгийн сөрөг нөлөө.
- 3.2. Эрсдэлийг үнэлэх: эрсдэлийн нөлөөллийн хүчин зүйлсийг ялгаж харах зорилгоор ач холбогдлын төвшингээр нь ангилж, үнэлэх ба эрсдэлийг хэмжихэд ашиглаж буй арга зөв эсэхийг тогтмол шалгана. Эрсдэлийг чанарын болон тоон хэрэгслүүдийг ашиглан үнэлнэ.
- 3.3. Эрсдэлийг удирдах: эрсдэлийн үнэлгээний үр дүнд эрсдэлд үзүүлэх хариу арга хэмжээг тодорхойлох ба эрсдэлийн удирдлагын арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлнэ.

ДӨРӨВ. БУСАД

- 4.1. Гүйцэтгэх удирдлага эрсдэлийн удирдлагын зааврын хүрээнд эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх зорилгоор төлөвлөгөө боловсруулж, байгууллагын эрсдэлийг тодорхойлон үнэлж, удирдах үйл ажиллагааг явуулна.
- 4.2. Гүйцэтгэх удирдлагын дэргэд байгууллагын эрсдэлийн удирдлагын төлөвлөгөөг хэрэгжүүлэх эрсдэлийн удирдлагын нэгж, эсхүл ажилтан томилж болох бөгөөд бусад гүйцэтгэх шатны удирдлагуудтай байнгын харилцан холбоотой ажиллана.
- 4.3. Гүйцэтгэх удирдлага эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө байгууллагад нийцсэн үр дүнтэй эсэх, төлөвлөгөөний гүйцэтгэлд хяналт тавьж ажиллана.